

RSA

“РЕЛАЭНС СЕКЮРИТИЗ
АУДИТ” ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
9-р хороо Компьютер молл 7024 тоот
Утас: 99813174

E-mail: rsamongolia@gmail.com

2020 • 03 • 24^{төдөхөн} 022/062
Танай _____ -ны № _____ -т

“Ногоон хөгжил үндэсний
иэгдэл” ХК-ийн
удирдлага-д

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ

Бид “Ногоон хөгжил үндэсний иэгдэл” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлан тэнцэл, санхүүгийн жилийн орлого, үр дунгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайландаа аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ногоон хөгжил үндэсний хөгжил” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлан, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлальнalын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.
Дүгнэлийн үндэслэл

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартгууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төловлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудиторын хулээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуулыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бид аудитын нягтлах ажлыг хийх явцдаа доорхи АОУС-уудыг мөрдөж ажиллалаа.

Үүнд: АОУС500, АОУС510, АОУС530...

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, толилуулах нь компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нехцел байцаалд уялсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолтуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материалыг буруу илэрхийлэлтүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.


Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материалыг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын зүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

Жич: "Ногоон хөгжил үндэсний нэгдэл "ХК-ий санхүүгийн бодит байдал 202 онд хийж гүйцэтгэсэн ажил болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дэлгэрэнгүйг тодруулга тайлангаас харна уу

3 - 7
(Энэхүү тайлан нь тоот хавсралтын хамт хүчин тоголдор болно)



2022:09.29 № 022/062